



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/06/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: Saranchimegtst@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал.....	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.4.1 Мөнгөн хөрөнгө	14
3.5.2 Авлага	14
3.5.3 Урьдчилгаа.....	15
3.5.4 Бараа материал.....	15
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө.....	15
3.5.6 Үндсэн хөрөнгө.....	15
3.5.7 Өр төлбөр.....	16
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал.....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.5.1 Завсрын аудитын талаар	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	21
5.3 Зөвлөмж.....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БНСБС	Байгалийн нөхөн сэргээх барьцаа сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмол сум
Утас: 70272582, Цахим илүүдэл: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 01/241
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нэгтгэсэн санхүүгийн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 3 тусгай сан, 1 төрийн сангийн нэгж нийт 11 тайлан нэгтгэгдсэн байна. Орон нутгийн төсвийн төвлөрүүлэн захирагчид нь зөвхөн гүйцэтгэл үр, дүнгээр санхүүжих байгууллагын орон нутгаас баталсан төсвийн хүрээнд тайлагнаж нэгтгэлд оруулсан.

Төв аймгийн Баяндэлгэр суманд 2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр дараах ажил хийгдсэн байна. Үүнд Хогийн машин худалдаж авахад 31,694.8 мянган төгрөг, мэдээлэл түгээх түгээх дэлгэц 39,639.6 мянган төгрөг, хүүхэд залуучуудын амралт чөлөөт цаг өнгөрүүлэх тоног төхөөрөмж 11,148.4 мянган төгрөг, Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж худалдан авахад 19,008.0 мянган төгрөг, ундны усны худаг урсгал засвар 16,215.2 мянган төгрөг, сумын 100-н жилийн ойг угтан гэрэлт гудамж байгуулах гэрэлтүүлэг, камержуулалд, нийтийн гудамжны гэрэлтүүлэг 100,988.3 мянган төгрөг, хүүхдийн тоглоомын талбайд тоглоом худалдан авах 25,000.0 мянган төгрөг, хог хаягдал ангилах хогийн сав, баг хорооны тохижилт 15,430.2 мянган төгрөг, Байдлаг, Галуут багийн гүний худаг 40,000.0 мянган төгрөг, Бактерийн бэлдмэл 19,000.0 мянган төгрөг, Бод малын эзмэг, зүүлт, бахь 10,640.0 мянган төгрөг, Малчдын зөвлөгөөн болон малчин эмэгтэйчүүдийн уулзалтад 15,000.0 мянган төгрөг зэрэг ажилд зарцуулагдсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг сумын ИТХ-ын хуралдаанаас 299,916.0 мянган төгрөгөөр тодотгон баталсан. Гүйцэтгэлээр нийт 283,621.3 мянган төгрөгийн татварын ба татварын бус орлогыг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг нийт дүнгээр 16,890.5 мянган төгрөгөөр буюу 94,38 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг шилжүүлэхдээ Сангийн яамнаас 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан бичгээр өгсөн заавар чиглэлийн дагуу орон нутгийн улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн 2,040,388.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 129,777.8 мянган төгрөгийн бараа материал, 10,261.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, 57,353.0 мянган төгрөгийн авлага, 10,955.1 мянган төгрөгийн үлдэгдлийг шилжүүлэн тайлагнасан байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга нийгмийн хариуцлагын хүрээнд ААНБ, орон нутгаас зохион байгуулж байгаа уралдаан тэмцээн, баяр ёслол, хүмүүнлэгийн ажил, байгаль хамгаалах үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох талаар 5 ААНБ-тай 22,600.0 мянган төгрөг гэрээ байгуулан хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай батламж гэрээ байгуулан ажиллаж 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/45 тоот захирамжаар сумдын 2022 оны үйл ажиллагааны үр дүнгийн тухай захирамжаар 80,47 буюу "Б" үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨ РӨ НГИЙН ДҮН		1,149,388.7	925,371.4
31	МӨ НГӨ Н ХӨ РӨ НГӨ	3а, 3б	494,120.2	371,617.6
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	418,165.2	397,026.5
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	237,103.3	156,727.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨ РӨ НГИЙН ДҮН		2,925,080.3	1,179,645.1
39	ҮНДСЭН ХӨ РӨ НГӨ	12а, 12б, 12в	2,925,080.3	1,179,645.1
39200	Биет хөрөнгө		2,803,546.9	1,139,476.8
39300	Биет бус хөрөнгө	13	121,533.4	40,168.4
3	НИЙТ ХӨ РӨ НГИЙН ДҮН III=I+II		4,074,469.0	2,105,016.5
4	НИЙТ Ө Р ТӨ ЛБӨ Р		20,216.3	4,936.7
41	БОГИНО ХУГАЦААТ Ө Р ТӨ ЛБӨ Р	15а, 15б	20,216.3	4,936.7
41300	Ө глөг	17а, 17б	20,216.3	4,936.7
5	ЦЭВЭР ХӨ РӨ НГӨ Ө МЧИЙН ДҮН		4,054,252.8	2,100,079.8
51	Засгийн газрын хувь оролцоо		4,054,252.8	2,100,079.8
51100	Засгийн газрын оруулсан капитал		616,518.0	150,370.7
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		616,518.0	150,370.7
51200	Хуримтлагдсан үр дүн		2,148,568.6	1,523,224.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,289,166.1	426,484.9
6	Ө Р ТӨ ЛБӨ Р, ЦЭВЭР ХӨ РӨ НГӨ Ө МЧИЙН ДҮН VI=IV+V		4,074,469.0	2,105,016.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,357,445.2	1,611,582.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО		172,578.7	272,169.7
110	Орлогын албан татвар		27,924.7	124,232.6
1100	Хувь хүний орлогын албан татвар		27,924.7	126,751.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	-2,519.1
113	Хөрөнгийн албан татвар		60,062.7	38,188.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж		84,591.3	109,748.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	488,793.1	486,026.6
120	Нийтлэг татварын бус орлого		488,793.1	486,026.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,696,073.4	853,386.6

II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	3,066,930.8	1,338,606.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,042,045.5	972,166.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,108,715.6	829,105.4
2101	Цалин хө лс болон нэмэгдэл урамшил		991,344.1	212,686.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд тө лө х шимтгэл		123,901.6	26,706.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		290,621.5	295,965.4
2104	Хангамж, бараа материалын зардал		45,018.9	15,983.1
2105	Нормативт зардал		203,714.1	44,342.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		3,308.2	2,517.0
2107	Томилолт, зочны зардал		2,011.5	4,776.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний тө лбө р, хураамж		3,232.6	18,753.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		445,563.2	207,374.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮ ЛЭГ		933,329.9	143,060.9
22	ХӨ РӨ НГИЙН ЗАРДАЛ		24,885.3	366,439.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		290,514.4	272,976.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		3,119.2	2,170,165.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		287,395.2	-1,897,189.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨ НГӨ Н ОРЛОГЫН ДҮН (I)	3,090,682.3	1,049,443.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	172,578.7	272,169.7
110	Орлогын албан татвар	27,924.7	124,232.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	27,924.7	126,751.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-2,519.1
113	Хө рө нгийн албан татвар	60,062.7	38,188.2
118	Бусад татвар, тө лбө р, хураамж	84,591.3	109,748.9
1180	Бусад нийтлэг тө лбө р, хураамж	6,426.7	2,813.7
1181	Газрын тө лбө р	5,146.8	16,030.1
1182	Байгалийн нө ө ц ашигласны тө лбө р	73,017.8	73,530.9
1183	Бусад татвар	0.0	17,374.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	279,460.5	-32,482.2
120	Нийтлэг татварын бус орлого	279,460.5	-32,482.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮ ЖИЛТИЙН ОРЛОГО	2,638,643.0	809,755.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,655,450.5	869,389.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,655,450.5	869,389.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,720,806.8	760,182.2

2101	Цалин хө лс болон нэмэгдэл урамшил	991,204.1	215,872.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд тө лө х шимтгэл	123,901.6	26,206.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	290,621.5	295,604.5
2104	Хангамж, бараа материалын зардал	41,944.9	14,186.0
2105	Нормативт зардал	127,845.9	240.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,490.0	4,017.0
2107	Томилолт, зочны зардал	1,844.0	4,776.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний тө лбө р, хураамж	3,528.6	71,842.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	130,426.3	127,436.8
211	Хүү	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	934,643.7	109,207.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨ НГӨ Н ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	435,231.7	180,053.8
V	ХӨ РӨ НГӨ ОРУУЛАЛТЫН МӨ НГӨ Н ЗАРДЛЫН ДҮН (V)	108,299.9	130,047.8
22	ХӨ РӨ НГИЙН ЗАРДАЛ	108,299.9	130,047.8
2200	Дотоод эх үүсвэрээр	108,299.9	130,047.8
VI	ХӨ РӨ НГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨ НГӨ Н ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-108,299.9	-130,047.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨ НГӨ Н ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-139,268.0	-172,508.5
14	Бусад эх үүсвэр	0.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨ ЛӨ ГДӨ Х ТӨ ЛБӨ РИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	139,268.0	172,508.5
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨ НГӨ Н ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	187,663.8	-122,502.5
101	Мө нгө , түүнтэй адилтгах хө рө нгийн эхний үлдэгдэл	306,456.3	494,120.2
20	Мө нгө , түүнтэй адилтгах хө рө нгийн эцсийн үлдэгдэл	494,120.2	371,617.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хө рө нгө /ө мч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,766,857.5	3,766,857.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын ө ө рчлө лт	1,923.5	1,923.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,768,781.1	3,768,781.1
4	Үндсэн хө рө нгийн дахин үнэлгээний ө сө лт бууралт	-1,923.5	-1,923.5
9	Тайлант үеийн үр дүн	287,395.2	287,395.2
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,054,252.8	4,054,252.8
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,054,252.8	4,054,252.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын ө ө рчлө лт	-56,983.6	-56,983.6

13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,997,269.1	3,997,269.1
19	Тайлант үеийн үр дүн	-1,897,189.3	-1,897,189.3
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,100,079.8	2,100,079.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,453,056.0	1,182,886.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	707,041.2	626,850.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	691,014.9	610,825.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	273,575.2	215,872.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,632.7	26,206.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	301,729.9	295,604.5
2104	Хангамж, бараа материалын зардал	14,790.5	14,186.1
2105	Нормативт зардал	240.0	240.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,350.0	4,017.0
2107	Томилот, зочны зардал	5,884.7	4,776.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	25,105.3	23,600.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,706.6	26,322.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,026.3	16,025.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,026.3	16,025.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	564,881.6	383,527.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	181,133.2	172,508.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,453,056.0	996,255.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	179,797.4	179,797.4
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	822,287.8	701,507.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	450,970.8	114,951.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	237,461.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	51,009.2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Ө мнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	176,534,142.63	76,033,410.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	176,534,142.63	76,033,410.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,791,401.50	53,409,207.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,914,014.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,743,392.00	0
2104	Хангамж, бараа материалын зардал	76,315.00	0
2105	Нормативт зардал	20,124,094.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,050,000.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	697,369.00	1,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,186,217.50	52,409,207.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,742,741.13	22,624,203.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,877,200.00	4,379,600.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,865,541.13	18,244,603.13
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	176,534,142.63	76,033,410.13
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	176,534,142.63	76,033,410.13
III	НИЙТ ЦЭВЭР МӨ НГӨ Н ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга Орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр, Засгийн газар, аймаг, сумын стратегийн зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг, Төв аймгийн засаг даргын харьяа байгууллага юм.

Баяндэлгэр сум аймгийн “Ногоон хөгжил-Баялаг бүтээгчдийг дэмжих” урианы жилийн хүрээнд хайлаас, улиас, үхрийн нүд, чацаргана, голт бор зэрэг мод бутны, тарьц суулгац 7476 ширхгийг айл өрх, иргэд, ААН, хүн эмнэлэг, дунд сургууль, ЗДТГ, Соёлын төвийн ногоон байгууламжийн хашаанд, Д.Нацагдоржийн хөшөөний өмнөх талбайд гүйлс,

тэхийн шээг, шар хуайс, голт бор зэрэг 200 гаруй мод тарьсан мөн сумын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүд 3714 ширхэг мод, тарьц суулгац суулгасан байна.

Төв аймгийн Баяндэлгэр суманд 2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр дараах ажил хийгдсэн байна. Үүнд Хогийн машин худалдаж авахад 31,694.8 мянган төгрөг, мэдээлэл түгээх түгээх дэлгэц 39,639.6 мянган төгрөг, хүүхэд залуучуудын амралт чөлөөт цаг өнгөрүүлэх тоног төхөөрөмж 11,148.4 мянган төгрөг, Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж худалдан авахад 19,008.0 мянган төгрөг, ундны усны худаг урсгал засвар 16,215.2 мянган төгрөг, сумын 100-н жилийн ойг угтан гэрэлт гудамж байгуулах гэрэлтүүлэг, камержуулалт, нийтийн гудамжны гэрэлтүүлэг 100,988.3 мянган төгрөг, хүүхдийн тоглоомын талбайд тоглоом худалдан авах 25,000.0 мянган төгрөг, хог хаягдал ангилах хогийн сав, баг хорооны тохижилт 15,430.2 мянган төгрөг, Байдлаг, Галуут багийн гүний худаг 40,000.0 мянган төгрөг, Бактерийн бэлдмэл 19,000.0 мянган төгрөг, Бод малын ээмэг, зүүлт, бахь 10,640.0 мянган төгрөг, Малчдын зөвлөгөөн болон малчин эмэгтэйчүүдийн уулзалтад 15,000.0 мянган төгрөг зэрэг ажилд зарцуулагдсан байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга нийгмийн хариуцлагын хүрээнд ААНБ, орон нутгаас зохион байгуулж байгаа уралдаан тэмцээн, баяр ёслол, хүмүүнлэгийн ажил, байгаль хамгаалах үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох талаар 5 ААНБ-тай 22,600.0 мянган төгрөг гэрээ байгуулан хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай батламж гэрээ байгуулан ажиллаж 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/45 тоот захирамжаар сумдын 2022 оны үйл ажиллагааны үр дүнгийн тухай захирамжаар 80,47 буюу "Б" үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга Монгол улсын Засгийн газар 311 тоот тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.7.1-д зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичгийг шалгахад баримт бичгийг батлаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баяндэлгэр сум нь Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,969,452.5 мянган төгрөгөөр буюу 51,66 хувиар буурсан байна. Энэ нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд улсын төсвийн байгууллага руу шилжсэнтэй холбоотойгоор Төсвийн тухай хуулийн дагуу жилийн эцсийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах талаар Сангийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан бичгээр өгсөн заавар, аргачлал, чиглэлийг баримталсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
			/мянган төгрөгөөр/
Мөнгөн хөрөнгө	494,120.2	371,617.6	-122,502.6
Авлага	418,165.2	397,026.5	-21,138.7
Бараа материал	237,103.3	156,727.3	-80,376.0
Үндсэн хөрөнгө	2,925,080.3	1,179,645.1	-1,745,435.2
Нийт хөрөнгө	4,074,469.0	2,105,016.5	-1,969,452.5
Өр төлбөр	20,216.3	4,936.7	-15,279.6
Засгийн газрын хувь оролцоо	4,054,252.7	2,100,079.8	-1,954,172.9
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	4,074,469.0	2,105,016.5	-1,969,452.5

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос дараах байдлаар өөрчлөгдсөн байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 371,617.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 122,502.6 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 132,415.5 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 397,026.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 21,138.7 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн төвийн авлагын үлдэгдэл 57,353.0 мянган төгрөгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 156,727.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 80,376.0 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 129,777.8 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,179,645.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,745,435.2 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 2,040,388.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Өглөг дансны үлдэгдэл 4,936.7 төгрөг болж, өмнөх оноос 15,279.6 мянган төгрөгөөр буурсан нь ЭЭС-ийн 8,160.7 мянган төгрөг, гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг,

Эмнэлэг зэрэг байгууллагуудын 10,886.3 мянган төгрөгийн өглөгийг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 2,100,079.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,954,172.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын авлага, засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 1,897,189.3 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 371,617.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 122,502.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Банкинд байгаа бэлэн мөнгө	494,120.2	371,617.6	-122,502.6
Төрийн сангийн харилцах	494,091.1	358,779.0	-135,312.1
Арилжааны банк дахь харилцах	29.1	12,838.6	12,809.5
Дүн	494,120.2	371,617.6	-122,502.6

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 358,779.0 мянган төгрөгийн 82,8 хувь буюу 297,119.9 мянган төгрөгийг Орон нутгийн ерөнхий орлого, 11,0 хувь буюу 39,459.6 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сан, 3,2 хувь буюу 12,046.9 мянган төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сан, 3,0 хувь буюу 10,650.0 мянган төгрөг БНСБС-ийн дансны үлдэгдэл эзэлж байна. Арилжааны банк дахь харилцах дансны 12,838.6 мянган төгрөгийн үлдэгдлийг Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл эзэлж байна.

Аудитын илрүүлэлт

ОНХС-аас Ундны усны худаг засвар, Малчдын зөвлөгөөн сургалт, туршлага солилцох үйл ажиллагааны мөнгийг олгохдоо ХХОАТ суутгаж олгосон зөрчилд зөвлөмж өгсөн. Сумын ИТХ-ын 2021 оны 17 дугаар “Сум хөгжүүлэх сангийн төсөв батлах тухай” тогтоолоор аж ахуйн нэгжид 20,000.0 мянган төгрөгийн зээл олгохоор дээд хэмжээг баталсан байхад 3 хоршоонд уг хэмжээг хэтрүүлэн 28,100.0 мянган төгрөг буюу нийт 84,300.0 мянган төгрөгийн зээл олгосон зөрчилд зөвлөмж өгсөн.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 397,026.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 21,138.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Дансны авлага	418,165.2	397,026.5	-21,138.7
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,025.0	1,029.6	4.6
Байгууллагаас авах авлага	98,098.7	33,313.4	-64,785.3
Хувь хүмүүсээс авах авлага	319,041.5	362,683.5	43,642.0
Дүн	418,165.2	397,026.5	-21,138.7

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 397,026.5 мянган төгрөгийн 90,95 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 9,05 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байна. Хувь хүмүүсээс авах авлагын 99,56 хувь буюу 361,100.0 мянган төгрөг нь хоршоо, хөгжүүлэх сангийн, байгууллагаас авах авлагын 100,0 хувь буюу 33,313.4 мянган төгрөгийн авлага нь

Орон нутгийн хөгжлийн сангийн авлагын үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 397,026.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 21,138.7 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн төвийн авлагын үлдэгдэл 57,353.0 мянган төгрөгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс үлдэгдэлгүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 156,727.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 80,376.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Түүхий эд материал	24,605.0	13,329.8	-11,275.2
Эм боох материал	24,605.0	13,329.8	-11,275.2
Хангамжийн материал	212,498.3	143,397.5	-69,100.8
Бичиг хэргийн материал	2,162.5	462.9	-1,699.6
Аж ахуйн материал	117,971.2	33,969.3	-84,001.9
Түлш, шатах тослох материал	875.2	6,368.4	5,493.2
Барилгын засварын материал	1,736.1	2,073.4	337.3
Хүнсний материал	4,891.2	287.2	-4,604.0
Бусад хангамжийн материал	64,229.9	77,674.1	13,444.2
Мал амьтад	20,632.2	22,562.2	1,930.0
Дүн	237,103.3	156,727.3	-80,376.0

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны үлдэгдэл 142,299.5 мянган төгрөгийн 90,79 хувийг ЗДТГ, 8,5 хувийг эмийн эргэлтийн сан, 0,7 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 156,727.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 80,376.0 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 129,777.8 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө үлдэгдэлгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,179,645.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,745,435.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Биет хөрөнгө	2,803,546.9	1,139,476.8	(1,664,070.1)
Барилга, байгууламж, орон сууц	2,457,234.3	666,890.3	(1,790,344.0)
Авто-тээврийн хэрэгсэл	54,975.4	126,229.9	71,254.5
Машин тоног төхөөрөмж(компьютер)	139,582.1	155,122.0	15,539.9
Зам, гүүрийн байгууламж	2,197.8		(2,197.8)
Тавилга, аж ахуйн эд хогшил	25,179.4	4,129.2	(21,050.2)
Бусад үндсэн хөрөнгө	96,763.6	187,105.4	90,341.8
Ном	27,614.3		(27,614.3)
Биет бус хөрөнгө	121,533.4	40,168.3	(81,365.1)
Програм хангамж	1,263.4	1,882.3	618.9
Бусад биет бус хөрөнгө	120,270.0	38,286.0	(81,984.0)

Дүн	2,925,080.3	1,179,645.1	(1,745,435.2)
------------	--------------------	--------------------	----------------------

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 99,65 хувь буюу 1,175,523.0 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,05 хувь буюу 854.0 мянган төгрөгийг ИТХ, 0,3 хувь буюу 2,978.1 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,179,645.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,745,435.2 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 2,040,388.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 4,936.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 15,279.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Өглөг	20,216.3	4,936.7	-15,279.6
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,100.0	3,600.0	2,500.0
Байгууллагад төлөх өглөг	19,047.5	1,336.7	-17,710.8
Татварын өглөг /ТӨҮГ/	68.8	0.0	-68.8
Дүн	20,216.3	4,936.7	-15,279.6

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өглөгийн дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 72,9 хувь буюу 3,600.0 мянган төгрөгийг сумын БНСБС, 20,7 хувь буюу 1,025.2 мянган төгрөгийг ЗДТГ, 6,3 хувь буюу 311.5 мянган төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангийн өглөг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт

Хоршоо хөгжүүлэх санд Орон нутгийн орлогоос 311,5 мянган төгрөгийн санхүүжилт өгснийг дансанд өглөгөөр тусгаагүй алдааг залруулж өглөгийн дансанд тусгасан.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,100,079.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,863,899.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Засгийн газрын хувь оролцоо	616,518.0	150,370.7	-2,863,899.9
Засгийн газрын оруулсан капитал	616,518.0	150,370.7	-1,045,144.7
Хуримтлагдсан үр дүн	2,148,568.6	1,523,224.2	-147,043.7
Өмнөх үеийн үр дүн	1,861,173.4	3,420,413.5	4,327,591.6
Тайлант үеийн үр дүн	287,395.2	-1,897,189.3	-4,474,635.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,289,166.1	426,484.9	-1,671,711.5
Дүн	4,054,252.7	2,100,079.8	-2,863,899.9

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 2,100,079.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,954,172.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын авлага, засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 1,897,189.3 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,353,355.0 мянган төгрөг, нийт зарлагыг 1,353,355.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 14,107.6 мянган төгрөгөөр нэмж, сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 16 тоот тогтоолоор урсгал зардлыг 1,339,247.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг сумын ИТХ-ын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 36 тоот тогтоолоор 1,453,056.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөгөөр татварын болон татварын бус орлогоор 299,916.0 мянган төгрөг, сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 522,371.8 мянган төгрөг, сумын төсвийн урьд оны шилжих үлдэгдэл 38,800.0 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 179,797.4 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл 171,895.0 мянган төгрөг, малын тоо толгойн татварын шилжих үлдэгдэл 59,162.6 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 181,113.2 мянган төгрөгийн нийт 1,453,056.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 355,737.8 мянган төгрөгийн санхүүжилт, сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 522,371.8 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 179,797.4 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 114,950.9 мянган төгрөг нийт 1,172,857.9 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, 280,198.1 мянган төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн батлагдсан төлөвлөгөөгөөр 181,332.2 мянган төгрөгийн эргэн төлөлт төвлөрүүлэхээс 114,950.9 мянган төгрөг бүрдүүлж 66,182.2 мянган төгрөгийн эх үүсвэр дутуу бүрдүүлсэн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг сумын ИТХ-ын хуралдаанаас 299,916.0 мянган төгрөгөөр тодотгон баталсан. Гүйцэтгэлээр нийт 283,621.3 мянган төгрөгийн татварын ба татварын бус орлогыг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг нийт дүнгээр 16,890.5 мянган төгрөгөөр буюу 94,38 хувиар биелүүлсэн байна.

Орлогыг нэр төрлөөр нь задалбал цалингийн орлого 7,397.1 мянган төгрөг буюу 8,77 хувиар, хөрөнгийн орлого 2,529.9 мянган төгрөг буюу 20,24 хувиар, Галт зэвсгийн албан татвар 510.0 мянган төгрөг буюу 56,67 хувиар, малын тоо толгойн албан татвар 86,083.9 мянган төгрөг буюу 74,7 хувиар, улсын тэмдэгтийн хураамж 1,234.3 мянган төгрөг буюу 58,78 хувиар, газрын төлбөр 13,969.9 мянган төгрөг буюу 46,57 хувиар тус тус тасарсан байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын 2022 онд зарцуулах зарлагын тодотгон батлагдсан төлөвлөгөө 1,45,056.0 мянган төгрөг, зардлын нийт гүйцэтгэл 1,182,886.7 мянган төгрөг буюу 270,169.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулж, гүйцэтгэл 81,41 хувьтай байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тайлант онд цалин, шимтгэлийн зардал 68,128.7 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 6,125.4 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 604.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 1,333.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн

зардал 1,504.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 1,383.2 мянган төгрөг, хөрөнгийн зардал 181,354.3 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээл 8,624.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглал хөтөлбөрийн /70106 /	393,266.3	329,655.9	63,610.4	83.8
2	ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага хөтөлбөрийн /70105/	55,321.5	48,697.0	6,624.5	88.0
3	Ерөнхий боловсрол хөтөлбөрийн /71802/	127,853.8	125,211.9	2,641.9	97.9
4	Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн /71801/	30,902.9	28,868.3	2,034.6	93.4
5	Эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөрийн /71602/	42,132.0	38,789.9	3,342.1	92.1
6	Соёл урлаг хөтөлбөрийн /71702/	96,364.7	95,389.1	975.6	99.0
7	Орон нутгийн хөгжлийн сан	526,081.6	343,765.7	182,315.9	65.3
8	Хоршоо хөгжүүлэх сан	181,133.2	172,508.5	8,624.7	95.2
Нийт дүн		1,453,056.0	1,182,886.3	270,169.7	81.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нэмэлт санхүүжилтийн тайланд ИТХ-д 1,000.0 мянган төгрөг, ЗДТГ-т Төв Чандмань ДЭХГ-аас 1,524.0 мянган төгрөгийн ундны усны нөхөн төлбөр, хуулийн дагуу сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчдын 4,379.6 мянган төгрөгийн тэтгэмж, аймгийн Засаг даргын 2022 оны №А/222 тоот захирамжаар малын гоц халдварт өвчнөөс урьдчилсан сэргийлэх шатахууны зардалд 971.0 мянган төгрөг, мөн №А/729 тоот захирамжаар өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан 10,000.0 мянган төгрөг шатахууны зардал, Статистикийн хэлтсээс ХАА-н тооллогын урамшуулал 3,348.1 мянган төгрөг, Чулуут интернейшнл ХХК-аас 3,000.0 мянган төгрөгийн хандив, 2021 оны эцэст төвлөрүүлсэн буцаан олголт 37,865.5 мянган төгрөг, газрын дуудлага худалдааны орлого 7,700.0 мянган төгрөг, бусад орлого 6,245.2 мянган төгрөг нийт 76,033.4 мянган төгрөгийн орлого нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 4,379.6 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 52,409.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт зарцуулж, 18,244.6 мянган төгрөгийг орон нутагт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 9 хөтөлбөрийн 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан

1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2022.01.01 2022.12.31	Сумын Иргэдийн төлөөлөгчид, зөвлөл, хороо, ажлын хэсгүүдэд хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх үйлчилгээ, Орон нутгийн өмчийн үйлчилгээ, Багийн Иргэдийн нийтийн Хуралд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааны хөтөлбөр батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын, тэргүүлэгчдийн хуралдааныг зохион байгуулж жилд 12 удаа хуралдсан байна. Хэрэгжилт 100%	55,321.5	48,697.0
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 4 зорилт, хэрэгжүүлэх 78 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 92,6%	393,266.3	329,655.9
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2022.01.01 2022.12.31	2022 оны 1 сараас Сум хөгжүүлэх санг шинээр Хоршоо хөгжүүлэх сан болгон журмыг дагаж мөрдөх Хоршоо хөгжүүлэх сангаас иргэн, хоршоонд олгох зээлийг журмын дагуу шаардлага хангасан төсөл шалгаруулан зээл олгох	2022 оны 01 сараас Хоршоо хөгжүүлэх сан болж журмын дагуу шинэчлэгдсэн. Хэрэгжилт 100% Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох төсөл хөтөлбөр зээлийн сонгон шалгаруулалт зарлагдаж 3 хоршоо, 6 иргэнд зээл олгон ажилласан	181,133.2	172,508.5
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2022.01.01 2022.12.31	Ерөнхий боловсрол сургууль нь 1 зорилт 2 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 98 %	127,853.8	125,211.9
5	71801- Сургуулийн өмнөх боловсрол	2022.01.01 2022.12.31	Сургуулийн өмнөх боловсрол нь 1 зорилт 2 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 98 %	30,902.9	28,868.3
6	71702-Соёлын үйлчилгээ	2022.01.01 2022.12.31	Соёлын төв нь 1 зорилт 2 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 91%	96,364.7	95,389.1
7	71602-Эрүүл мэндийн төв	2022.01.01 2022.12.31	ЭМТ нь 1 зорилт 2 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 91%	42,132.0	38,789.9
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт он дамжин хийгдэх 5 төсөл, шинээр хэрэгжих 6 төслийг 179,797.4 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 10, хэрэгжээгүй 1 хөрөнгө оруулалтын ажил, хэрэгжилт 88%	526,081.6	343,765.7

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөрийн шалтгаан нөхцөл байдлын талаар авч үзэхэд ЗДТГ -ын орон тоо дутуу ажилласнаас цалин, шимтгэлийн зардал хэмнэгдсэн, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлууд бүрэн хийгдээгүйгээс хэрэгжилт 81,41 хувьтай байна .

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 01/70 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг үзүүлэлтээр Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн 2022 оны нийт зарлага 1,453,056.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 21,795.84 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 17,436.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баяндэлгэр сумын ОНХС-ийн хөрөнгөөр 314,200.0 мянган төгрөгийн 11 ажил хийгдсэн Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-д заасны дагуу тендер шалгаруулалттай холбоотой мэдээллийг байршуулаагүй. Мөн Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан шийдвэрүүдийг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын ХХС-ийн хөрөнгөөр төсөв хөрөнгө зарцуулахтай холбоотой 2 тушаал гарсныг мэдээлээгүй. Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг мэдээлэх цэсэд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 4 гүйлгээ, зарлагын 9 гүйлгээний нийт 366,192.9 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Эргэлтийн эмийн сан Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг мэдээлэх цэсэд 5 сая төгрөгөөс дээш 22,700.0 мянган төгрөгийн 2 орлогын, 33,965.6 мянган төгрөгийн 4 зарлагын гүйлгээ нийт 56,665.6 мянган төгрөгийг мэдээлээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж Сумын төсвийн орлого бүрдүүлэлтийн талаар аймгийн төсвийн орлого бүрдүүлэлтийн талаар, татварын дутуу төлөлтийн талаар, газрын эрх шилжүүлсэн орлогын талаар, хоршоо хөгжүүлэх сангийн талаар, Байгалийн нөхөн сэргээх барьцаа сангийн талаар хэрэгжүүлэх 6 зөвлөмж хүргүүлж ажилласан бөгөөд хэрэгжилт хангалтгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой, хоршоо хөгжүүлэх сангийн талаар албан шаардлага, зөвлөмж өгөгдсөнийг 74,6 хувь хэрэгжилтэй Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 03/416 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Үзүүлэлт	Өмнөх оны аудитын үзүүлэлт		Биелэлт		
	тоо	дүн	тоо	дүн	хувь
Төлбөрийн акт	4	6,591.4	4	6301.4	95.6
Албан шаардлага	2	45,036.2	2	31,975.7	71.0
Зөвлөмж	4	52,380.8	4	39,285.6	75.0
Нийт дүн	10	104,008.4	10	77,562.7	74.6

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын дараагийн аудитаар хандивын орлого бүрдүүлэлтэд түүний бүртгэлийн талаар анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 2,281,360.3 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 2,281,360.3 мянган төгрөгийн алдааг залруулав.

1. Нэгтгэсэн санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 43,255.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

2. Улсын төсөв рүү шилжсэн байгууллагуудын хаалтын балансыг давтан шалгахад 2,238,104.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “ангилал”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 17,111.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс зөрчлийг давтан гаргахгүй байх 17,111.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

- 1.Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт:

Орон нутагт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөг 16,890.0 мянган төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хууль 41 дүгээр зүйлийн 41.2-д “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Төсвийн орлогын бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлж нэр төрлөөр бүрэн биелүүлэх талаар үр дүнд хүрч ажиллах

- 2.Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт:

Татварын хэлтсийн гаргасан орлогын мэдээ санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь татварын орлогын мэдээ 221.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Татварын болон татварын бус орлогын мэдээг орлогын дансны хуулганаас зөрүүтэй тайлагнадаг зөрчлийг арилгаж, мэдээний үнэн зөв байдалд тавих хяналтыг сайжруулах

- 3.Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

ОНХС-аас Ундны усны худаг засвар, Малчдын зөвлөгөөн сургалт, туршлага солилцох үйл ажиллагааны мөнгийг олгохдоо ХХОАТ суутгаж олгосон байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу албан татвар ногдуулах орлогоо өөрөө үнэн зөв тодорхойлж, доор дурдсан хугацаанд албан татварыг холбогдох төсөвт төлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийг мөрдөж, зөрчлийг давтан гаргахгүй байх ба Татварын хэлтэст татвар суутгаагүй орлого шилжүүлсэн тухай тайланг тухай бүр гаргаж өгч байх

4. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төв аймгийн Баяндэлгэр сумын ОНХС-ийн хөрөнгөөр 314,200.0 мянган төгрөгийн 11 ажил хийгдсэн Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-д заасны дагуу тендер шалгаруулалттай холбоотой мэдээллийг байршуулаагүй. Мөн Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан шийдвэрүүдийг шилэн дансанд мэдээлээгүй, ХХС-ийн хөрөнгөөр төсөв хөрөнгө зарцуулахтай холбоотой 2 тушаал гарсныг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 4 гүйлгээ, зарлагын 9 гүйлгээний нийт 366,192.9 мянган төгрөгийг мэдээлээгүй, ЭЭС-ийн хувьд 5 сая төгрөгөөс дээш 22,700.0 мянган төгрөгийн 2 орлогын, 33,965.6 мянган төгрөгийн 4 зарлагын гүйлгээ нийт 56,665.6 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах тушаал, шийдвэрийн мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх, мэдээллийг бүрэн, ойлгомжтой мэдээлсэн эсэхэд дотоод хяналтыг сайжруулж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга	2	2,281,360.3			2	2,281,360.3	2	2,281,360.3				
Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар	1	83,664.8			1	83,664.8	1	83,664.8				
Төв аймгийн Баяндэлгэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1	6,624.5			1	6,624.5	1	6,624.5				
Төв аймгийн Баяндэлгэр сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	311.5			1	311.5	1	311.5				
Дүн	5	2,371,961.1	-	-	5	2,371,961.1	5	2,371,961.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга	2	17111.5					2	17,111.5
Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар	6	36302.7	5	19,106.0			1	17,196.7
Төв аймгийн Баяндэлгэр сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	799.9					1	799.9
Төв аймгийн Баяндэлгэр сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	84300.0						
Дүн	10	54,214.1	5	19,106.0	-	-	4	35,108.1

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төв аймгийн Баяндэлгэр сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	314,226.8					1	314,226.8
Төв аймгийн Баяндэлгэр сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	366,192.9					1	366,192.9
Төв аймгийн Баяндэлгэр сумын Эмийн эргэлтийн сан	1	56,665.6					1	56,665.6
Дүн	3	737,085.3					3	737,085.3